



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/18

Чингис хот

Цаг агаарт зориудаар нөлөөлж,
болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх
ажилд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.7, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.13 дахь заалтууд, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ой, хээрийн түймрийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түймэр унтраахад дэмжлэг үзүүлэх, газар тариалан, бэлчээрийн ургамлын ургалтад шаардлагатай хөрсний чийг болон гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэх, хуурайшилт, цөлжилтийг сааруулах зорилгоор аймгийн хэмжээнд цаг агаарт зориудаар нөлөөлж, тунадас нэмэгдүүлэх экспедицийн 2021 оны үйл ажиллагааны зардалд 10000000 /арван сая/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3. Экспедицийн бэлтгэл, бэлэн байдлыг хангаж шаардлагатай үед цаг агаарт зориудаар нөлөөлж, тунадас нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, тухай бүр тайлагнаж ажиллахыг аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга /Б.Хэрлэнчимэг/-д үүрэг болгосугай.

4. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн Гамшгийн эрсдлийг бууруулах зардлаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010088

01 Аймгийн Засаг даргын 2021 оны
... дугаар сарын 13 өдрийн А/18
дугаар захирамжийн хавсралт



Зардлын тооцоо

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ /төг/
1	Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зардал			2000000
2	Шатахуун			5000000
3	Томилолт			3000000
	Нийт			10 000 000